

## СОНСГОЛОН БАРМАТ ХК-ны Гүйцэтгэх удирдлагаас

### 2015 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан

2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доорхи үндсэн чиглэлээр явагдсан.

Хийж гүйцэтгэсэн ажлын ихэнх хувийг үйлдвэрлэлийн бус чиглэлтэй байсан нь барилгын түүхий эд материалын хэрэгцээ захиалга эрс бага байсантай холбоотой байсан болно.

- БОЦ –н боловсруулах цехийн барилгын засвар
- Төмөр замын засвар
- Думпкар вагон засвар
- Элс хайрганы үйлдвэрлэл

БОЦ-ийн боловсруулах цехийн барилгын засвар:

БОЦ-ийн боловсруулах цехийн барилгын засварын ажлын зорилго нь 2009 оноос хойш ашиглалтгүй байж цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон хуучин тоног төхөөрөмжүүдийг задалж гарган талбайг султгаж складын зориулалтаар ашиглахад бэлтгэхэд чиглэгдсэн.

Энэ ажлын хүрээнд: Аспирацын 7 ширхэг төхөөрөмж, холбогдох тоног хэрэгсэл хашлага хамгаалалт, шат тавцан, 2 ширхэг туузан зөөгүүр, 8 ширхэг шигшүүр, элс дамжуулах туузан зөөгүүр, нөөцийн бункерүүд, тэдгээр суурь хашлага хамгаалалт, агааржуулалтын систем, ус дамжуулах хоолойн тоног хэрэгсэл, раж, хашлага хамгаалалт хоолойнуудыг бүрэн задалж зөөж гаргасан. Тоног төхөөрөмжийг задалж гаргасаны дараа төхөөрөмжийн бетон суурьнууд болон талбайд хуримтлагдсан элс хайрганы үлдэгдлийг бүрэн цэвэрлэж талбайг складын зориулалтаар ашиглахад бэлтгэсэн. Мөн цех рүү орох хаалгыг гүйдэг хаалга болгон өөрчилсөн. Цехэд байсан 5тн даацтай гүүрэн краныг иж бүрэн засварлаж ашиглалтад бэлтгэсэн бөгөөд задалж гаргасан тоног төхөөрөмжийн кабель утсуудыг тасалж гаргасан.

Төмөр зам засвар

Төмөр замын засварын ажлаар 3-р замын дэр модыг бетон болгон сольж дуусгах, 2,3-р замыг холбосон суман шилжүүлгийг нэмж тоноглох, 2-р замыг өргөж чигжин чиг татах ажлуудыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн.

Думпкар вагон засвар

2009 оноос хойш ашиглалтгүй зогссон думпкар вагонуудыг сэргээн засварлаж ашиглалтад оруулах зорилгоор нийт 35ш вагоноос эхний ээлжинд засварлаж ашиглах бололцоотой 24 вагоныг сонгож Зүүнхараа вагон депод засуулахаар гэрээ байгуулж, эхний 11 вагоныг иж бүрэн засуулж авсан ба одоогийн

байдлаар 4 вагон засварт байгаа 9 вагон нь 2016 онд засварт орохоор хүлээж байна.

Вагон засварын ажил нэлээд их өндөр өртөгтэй бөгөөд 2015 онд 9 вагоныг засварт явуулж амжаагүй нь хөрөнгө мөнгөний хүрэлцээгүй байсантай холбоотой.

Элс хайрганы үйлдвэрлэл.

2015 онд барилгын салбар хямралтай байснаас элс хайрганы эрэлт хэрэгцээ эрс багассаны улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бараг явагдаагүй гэхэд болохоор дүр зурагтай байсан ба гэрээт байгууллагын захиалгаар элс 572 м.куб хайрга 1274 м.куб нийт 1846 м.куб хайрга үйлдвэрлэж борлуулалт хийсэн нь барилгын ажил хэвийн явагдаж байх үеийн 1 сарын үйлдвэрлэлийн дундаж хэмжээнээс ч бага байсан болно. Ийм учраас 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа үндсэндээ ашиг орлогогүй зөвхөн зардал гаргах талдаа давуу байсаныг тэмдэглэх нь зүйтэй юм.

2015 оны сүүлийн 3 сард гадны үйлчлүүлэгч байгууллагын хүсэлтээр “Тийс Монгол” ХХК түрээсэлж үйл ажиллагаа явуулдаг объект дээр зарим нь засвар үйлчилгээний /барилгын/ чиглэлийн ажлуудыг өөрийн ажилчдын хүчээр хийж гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн байдал

2015 онд 37,3 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, 188,5 сая төгрөгийн зардал гарсан ба нийт 151,2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Улсын төсөвт оруулсан татвар хураамжийн хэмжээ 2,8 сая төгрөг. Орон нутгын төсөвт төлсөн төлбөр хураамж 6,5 сая төгрөг нийт 9,3 сая төгрөг төлсөн.

Зардалын задаргааг хийвэл

Цалин -17,9%

Ашиглалт -1,8%

Сэлбэг материал-71,8%

Түлш шатахуун-2,4%

ЗАА-6,1%

2016 оны Зорилт

1. Үйлдвэрийн төмөр замыг бүрэн засварлаж дуусгах, Төмөр замыг нээлгэх
2. Үлдсэн думпкар вагоны засварыг 5-р сард багтааж дуусгах
3. Төмөр замын тээврийг сэргээх талаар дараалсан арга хэмжээг холбогдох газруудтай хамтарч авах.
4. БОЦ-ийн борлогдоогүй нөөцлөгдсөн 5-15, 10-20, 20-40 хайргуудыг дахин боловсруулах буюу борлуулах үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулах
5. Барилгын материалын Терминалыг өөрийн Төмөр зам, барилга байгууламж, талбайд түшиглэн байгуулах

Захирал



С.Сүхбаатар